



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 185

Улаанбаатар хот

Үнэлгээ хийх тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 25, 26, 31 дүгээр зүйлийг үндэслэн  
ТУШААХ нь:

1. Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөл олгох шалгалтын сорилын санд үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсгийн дарга, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/-т үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080619

Эрүүл мэнд спортын сайдын  
2015 оны 05 сарын 07 өдрийн  
185 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: Э.Оюунсүрэн, Эрүүл мэнд, спортын яамны /ЭМСЯ/ Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Д.Баясгалан, ЭМСЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн

Гишүүд:

С.Отгонсүх, ЭМСЯ-ны Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн

Мэргэжлийн салбар зөвлөлүүд

Д.Уранчимэг, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн /ЭМХТ/ ЭМХА-ны дарга

Л. Бор, ЭМХТ-ийн мэргэжилтэн

Х.Хонгорзул, ЭМХТ-ийн мэргэжилтэн

П.Эрдэнэ-Очир, ЭМХТ-ийн мэргэжилтэн

Д.Отгонбаяр, Ач Анагаах ухааны их сургуулийн Боловсрол эрхэлсэн дэд захирал

Эрүүл мэнд спортын сайдын  
2015 оны 05 сарын 07 өдрийн  
185 дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

### Үндэслэл:

Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтыг авч эхэлснээс хойш сорилын асуултуудтай холбоотой гомдол удаа дараа гарч байсан ба 2014 оны төгсөгчдийн лицензийн шалгалтад АШУҮИС-ийн өгсөн үнэлгээгээр найдвартай байдал нь 0,74 буюу харьцангуй муу, ялгах индекс сөрөг, хүнд зэргийн тест байсан хэмээн дүгнэсэн. 2015 оны 3 сарын 27-ны өдрийн байдлаар ЭМХТ-ийн зөвшөөрлийн шалгалтын сорилын санд 13 чиглэлийн нийт 15414 сорил байна. Үүнээс 2427 буюу нийт сорилын 15,7% -ийг ямар нэгэн шалтгааны улмаас (сорилын түлхүүр буруу, асуулт алдаатай, гм гомдол шалгуулагчаас байнга гардаг) идэвхгүй болгосон байна. Тухайлбал: цахим сувилахуйн нийт сорилын 44,6% нь буюу 449 сорил, ерөнхий мэргэжлийн эмчийн 1364 сорил буюу 20 % нь идэвхгүй хэлбэрт байгаа нь идэвхгүй сорилын хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Иймээс нийт сорилын санд хяналт үнэлгээ хийх шаардлага зайлшгүй тавигдаж байна.

Цахим шалгалтын тогтолцоонд шилжсэнээс хойших 1 жилийн хугацаанд давхардсан тоогоор нийт 7570 эмч, эмнэлгийн мэргэжилтэн зөвшөөрлийн шалгалтанд орсноос 1094 хүн тэнцсэн байна. Дундаж амжилт 14,4% байна.

2014 оны 6 сард АШУҮИС-ын 321 төгсөгчдөөс цахим сангаас сонгосон 6 вариантын тус бүр 100, нийт 600 сорилоор цаасан хэлбэрээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт авсан ба тэдгээрийн зөвхөн 18 нь (15 нь 70-79%-ийн амжилтаар "С", 3 нь 80-89%-ийн амжилтаар "В") тэнцсэн байна. АШУҮИС-ийн сургалтын албанаас зөвшөөрлийн шалгалтад ирсэн сорилуудад дүн шинжилгээ хийн ЭМХТ-д ирүүлсэн болно. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн хариултууд ижил тул сонгоход хүндрэлтэй, зарим асуултууд сонгох боломжгүй хариулттай, сорилын асуултууд үсэг найруулгын алдаатай, сорилын найдвартай байдал (сорилыг дахин авахад шалгалтын дүн ижил байх магадлал)-ын дундаж үзүүлэлт нь (Kuder Richardson коэффициент 0.74) байх ёстой 0,9 түвшнээс доогуур, ялгах индекс (шалгуулагчдийг мэдлэгээр нь ялгаж буй эсэх үзүүлэлт)-ийн хувьд 600 сорилоос 98 сорил шаардлага хангахгүй, хүнд хөнгөний зэргийн үнэлгээгээр 120 сорил хэт хүнд байсан хэмээн дүгнэсэн.

Сорилуудын бөглөгдсөн байдлын дундаж амжилтыг авч үзвэл 54%-тай байсан ба нийгмийн эрүүл мэндийн чиглэлээрх сорилуудын бөглөгдсөн байдлын амжилтын үзүүлэлт 39%, ерөнхий мэргэжлийн эмчийнх 46% буюу хамгийн муу байгаа нь энэ чиглэлийн сорил хүнд байх магадлалтайг харуулж байна. Мөн 50%-иас доош амжилттай бөглөгдсөн 5664 сорил байгаа ба нийгмийн эрүүл мэндийн сорилын 68,8%, ерөнхий мэргэжлийн эмчийн сорилын 52,5%, бага эмчийн сорилын 46,4% нь 50%-иас доош амжилттай бөглөгдөн хамгийн муу бөглөгдсөн сорилд тооцогдож байна.

"Шалгалтын журам батлах тухай" ЭМС-ын 2014 оны 157 тоот тушаалын дагуу үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн элсэлт, төгсөлтийн онолын шалгалт цахим хэлбэрээр явагдах ёстой ба зөвшөөрлийн шалгалтын сорилын санд байршсан

сорилуудад үнэлгээ хийн алдаатай сорилуудыг засварлах, хүнд хөнгөний зэргээр ялган зөвшөөрлийн, үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтын элсэлтийн, төгсөлтийн хэмээн ангилах шаардлага гарч байна.

**Зорилго:**

Мэргэжлийн зөвшөөрлийн шалгалтанд ашиглаж байгаа сорилын санд үнэлгээ хийж зөвшөөрлийн шалгалтын чанар, үр дүнг сайжруулах

**Зорилт:**

- Мэргэжлийн зөвшөөрөл олгоход үндсэн шалгуур болгон ашиглаж байгаа сорилын сангийн хүчин төгөлдөр байдал, найдвартай байдал, гүйцэтгэж хийж болохуйц байдлын үнэлгээг хийх
- Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэгийн түвшин, зэргийн ялгааг үнэлж чадахуйц түвшин тогтоох

**Хугацаа:**

2015 оны 05 дугаар сард

**Үр дүн:**

Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зөвшөөрлийн шалгалтын сорилын сангийн үнэлгээг хийж гүйцэтгэсэнээр:

1. Тухайн эмч, мэргэжилтэнүүдэд сорилын асуумж, арга аргачлал нь энгийн ойлгомжтой болж тухайн мэргэжилтний үнэлгээ, амжилтын хувь нэмэгдэнэ.
2. Мэдлэгийн түвшин, зэргийн ялгааг үнэлж чадахуйц сорилын сантай болсон байна.